

## Тендерийн урилга

Огноо: 2019-10-28

Төслийн нэр, дугаар: Техникийн нөхөн сэргээлт хийлгэх үйлчилгээ авах

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны харьяа “Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн нэгж нь эрх бүхий тендерт оролцогчдыг *Бэрхийн уурхайн 102000 м<sup>3</sup> эзэлхүүнтэй талбайн техникийн нөхөн сэргээлт хийх* үйлчилгээ үзүүлэх тухай битүүмжлэл бүхий тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендерийн бичиг баримтын иж бүрдэл бүрийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр 50.000 төгрөгөөр БЗД-ийн 22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын байрны 103 тоот, “Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв” төслийн нэгжээс худалдан авах боломжтой. Сонирхсон оролцогчид дэлгэрэнгүй мэдээллийг дээр дурдсан хаягаар хандан авч болно.
3. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба *Тендерийн үнийн дүнгийн 2%-тай тэнцэх үнийн дүн* бүхий чөлөөтэй хөрвөх валют бүхий тендерийн баталгаатай хамт ирүүлнэ. Тендерийг *2019 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 11<sup>00</sup> цагаас* өмнө БЗД-ийн 22-р хороо, “Монголросцветмет” ТӨҮГ-ын 103 тоот, “Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв төслийн нэгж” хаягаар ирүүлэх бөгөөд тендерийг нээхээр заасан хугацаанд уг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан нийтийн өмнө нээнэ.

“МОНГОЛЫН ДАЛД УУРХАЙН МУЗЕЙ, СУРГАЛТ, СУДАЛГАА, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ТӨВ” ТӨСЛИЙН НЭГЖ